

**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР” ОНӨТҮГ-ЫН 2024 ОНЫ БҮТЭН
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая.т өг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:								
1.1. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл								
4.1.1 Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийн нэмэгдүүлсэн байна.								
1	1.1.1	1.1.1.3 Байгууллагын өмчид бүртгэлтэй эд хөрөнгийг түрээс үйлчилгээнд гаргаж төсвийн орлого бүрдүүлнэ.		Өмчийн түрээсийн орлого	100,0	145,3	Тайлант хугацаанд 145,3 сая төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөө гаргаснаас 2024 оны 11 сарын байдлаар 279,0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 92% давуулан биелүүлсэн.	100%
4.1.3 Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулсан байна.								
2	1.1.2	1.1.2.1 Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, батлагдсан төсвийн хүрээнд сар, улирлын хуваарийн саналыг бэлтгэж санхүүгийн сахилга батыг сайжруулж ажиллана.		Нийт батлагдсан төсөв	991,1	1,151,3	Төсвийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хуулийн хүрээнд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж 2024 оны 11 сарын байдлаар 249,9 сая төгрөгний хэмнэлт үүсгэн ажилласан. Санхүүгийн сахилга бат сайжруулж, төсвийн жилд өр, авлага үүсгэхгүй, төсвийг зориулалтын зүйлд зарцуулан ажиллаж байна.	100%
1.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр								
4.1.4 Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.								
3	1.2.1	4.1.4.1 Төсвийн ерөнхийлөн Захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын “Шилэн		Тухайн жилд оруулах	155	159	“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тайлант оны 11 сарын байдлаар нийт	95%

		дансны тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавьж, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангуулна.		мэдээний тоо			мэдээллэх 148 мэдээнээс хугацаандаа мэдээллэсэн 138, хугацаа хоцорч мэдээллэсэн 10, мэдээллээгүй мэдээ 0 байна. Шилэн дансны хөтлөлтийн байдалд хяналт шалгалт хийхэд тайлант хугацаанд 10 мэдээг хугацаа хоцорч шивсэн зөрчил гаргасан байна. Хяналт шинжилгээ үнэлгээний тайланг Даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллав.	
4	1.2.2	“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтийг хангаж, газрын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллүүдийг ил тод, нээлттэй байлгах арга хэмжээг зохион байгуулна.		Ил тод байршуулсан мэдээллийн тоо	63	80	Хуулийг хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/14 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 48-н мэдээллийг цахим хуудаст бүрэн байршуулсан. Мөн бусад 33 төрлийн мэдээ мэдээлэл, цаг үеийн шинжтэй зохион байгуулагдсан 271 төрлийн мэдээллийг байршуулан ажилласан. Байгууллагын мэдээллийн самбар дахь мэдээллийг сар бүр шинэчлэн харилцагч байгууллага иргэдэд хүргэх мэдээллий ил тод байдлыг хангаж ажиллаа. самбар дээрх мэдээллийг шинэлчэн гаргаж иргэдэд мэдээлэл хүргэж байна.	100%
4.2.2. Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.								
5	1.2.3	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад		Сургалтад	20	27	Аавилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг	100%

		ажилтнуудыг хамруулж, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүргүүлж ажиллана.		хамрагдсан ажилтны тоо			дотооддоо 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 50 албан хаагч хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Авилгатай тэмцэх газраас хамтран зохион байгуулсан Авлига, ашиг сонирхолын тухай хуулийн сургалтад Ерөнхий нягтлан бодогч хамрагдсан. 2024 оны 11 дүгээр сарын 21-нд НЗДТГ, Авилгатай тэмцэх газар, Ёс зүйн хороотой хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад Газрын дарга болон албадын дарга нар хамрагдсан. Газрын хэмжээнд Хөрөнгө орлогын мэдүүлэг өгөх үүрэгтэй Газрын дарга, Ерөнхий нягтлан бодогч нар ХОМ-ийг хуулийн хугацаандаа багтаан мэдүүлсэн.	
1.3.Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө								
240.Тусгай хэрэгцээний ногоон байгууламж, хамгаалалтын зурвасыг нэмэгдүүлэх								
6	1.3.3	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулна.		Ногоон байгуул амжийг нэмэгдүүлэх, арчилж ургуулсан мод, бут, сөөгийн тоо	750	1000	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хүрээнд Хүй долоо худагт 45ш чацаргана, 327ш Улиас, 61ш Хайлаас, 39ш Монос, 80ш Шар хуайс, 13ш үхрийн нүд, 6ш Гүйлс, 15ш Гацуур мод 10Ш Нарс мод Нийт 600 мод шинээр тарьсан. Тус байгууллагын эзэмшил газарт байгаа нийт 2300 модны арчлалт хамгаалалтыг тухай бүр хийж байна.	100%

ХОЁР. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

7	2.1	Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг хангаж, 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах		Хөтөлбөрийн биелэлтийн хувь	70%	100%	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тусгайлан төсөв тавигддаггүй тул дотоод нөөц бололцоондоо тулгуурлан хэрэгжүүлэх 11 заалт бүхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажилласан. Ажлын нөхцөл байдлыг сайжруулж зуны ажлын гутал 9ш, өвөл, зуны нийт 22 ш хувцасаар ажилчдыг хангасан. Тайлант хугацаанд дотооддоо болон дээд газраас зохион байгуулсан 29 удаагийн сургалтад давхардсан тоогоор 175 албан хаагчийг хамруулж ажиллаа. Үүнээс: дотооддоо 6 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 140 албан хаагчийг хамруулсан.	100%
8	2.2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах.		Зохион байгуулсан ажлын тоо	2	4	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Жендерийн эрх тэгш байдлын хангах хуулийн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх тухай 1 удаагийн сургалтыг дотооддоо зохион байгуулсан нийт 28 ажилтан, албан хаагч хамрагдсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Жендерийн эрх тэгш байдлыг хангаж 1 постер мэдээг ERP системд байршуулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал болон эрүүл ахуйн тухай хуулийн заалтуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон	100%

							тохижилт, үйлчилгээний албаны 15 ажилчдад өглөө бүр аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч хэрэгжилтийг ханган ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай сургалтыг сургагч багш н.Мөнхсүрэнг урьж 32 ажилтан, албан хаагчдыг хамруулан 2 цагийн сургалтыг зохион байгуулсан. Хөдөлмөр хамгааллын чиглэлээр хүй 7 худгийн 4 агуулах дээр гал түймэрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж байршуулсан. Тайлант хугацаанд тухайн байгууллага дээр хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой зөрчил гараагүй.	
9	2.3	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас жил, бүтэн жил, бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж дээд шатны байгууллагад тайлагнах		Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	2	4	Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жил болон жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг Газрын даргад танилцуулж 2024 оны хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, хэрэгжиж дуусаагүй арга хэмжээг дараа оны 1-р улиралд багтаан хийж хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч ажиллав. Хариутай бичгийн шийдвэрлэлт, erp.ulaanbaatar.mn программын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж тайлант хугацаанд 151 албан бичиг ирсэнээс 7 албан бичгийг хугацаа хоцорч шийдвэрлэсэн зөрчил илэрсэн. Зөрчил гаргасан албан хаагчдад зөвлөмж өгч ажилласан.	100%

							Тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 120 ажилтны ажлын цаг ашиглалтын байдалд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Цаашид анхаарах асуудлуудаар зөвлөж өгч ажиллав. Нийслэлийн Засаг даргын 8 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ERP Ulaanbaatar системийн Хяналт шинжилгээ цэсэд шивж оруулан тайлагнаж ажиллав.	
10	2.4	Баримт нягтлан шалгах комиссын үйл ажиллагааг тогтмолжуулах, байгууллагад Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлаж , мөрдүүлэх , 2023 оны архивын баримтыг хуваарийн дагуу хүлээн авах, нөхөн бүрдүүлэлт хийх.		Албан хэрэг хөтлөлт ийн нийтлэг журмын хэрэгжилтийн хувь, баримтын тоо	80	100	Газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ний А/06 дугаар тушаалаар баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулан Архив, албан хэрэг хөтлөлтийн баримт бичигт нягтлан шалгалт хийж комиссын бүрэлдэхүүн байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулан Нийслэлийн Архивын газарт хүргүүлж, №46 тоот захирамжлалын акт авсан. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 109 баримт, байгууллагын даргын 2023 оны 31 ширхэг А, 97 ширхэг Б тушаалуудыг цахим архивд шилжүүлж Нийслэлийн архивын газарт хүлээлгэн өгсөн. 2013-2023 оны байнга, захирамжлал, 70 жил хадгалах, түр хадгалах баримтыг он цаг, агуулгаар нь ангилан ялгаж дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Байгууллагын архивт	100%

							2013-2020 оны байнга, 70 жил, түр, байгууллага дээр байнга хадгалагдах баримтуудад иж бүрэн нягтлан шалгалт, техник боловсруулалтын ажил хийсний үр дүнд дараах хадгаламжийн нэгжийн бүртгэлийг үйлдсэн. Үүнд: • Байнга хадгалах баримтын бүртгэл 2013-2020 оны 17 хадгаламжийн нэгж • 70 жил хадгалах баримтын бүртгэл 2013-2020 оны 20 хадгаламжийн нэгж • Түр хадгалах баримтын бүртгэл 2013-2020 оны 213 хадгаламжийн нэгж (Лавлагаа мэдээллийн ач холбогдолгүй хадгалах хугацаа дууссан 2013-2023 оны баримтыг он, цаг, агуулгаар нь ангилан ялгаж баримтын жагсаалт үйлдэв).	
11	2.5	Байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөлийг улиралд 1 удаа хуралдуулж шаардлагатай үед хяналтын тооллого хийх, гарсан шийдвэрийг тухай бүрт нь танилцуулж тайлагнах.		Хурлаар шийдвэр лэсэн асуудлын тоо	3	4	Байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материал тоолох комиссыг Газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/16 тоот тушаалаар байгуулсан. Байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөл нь тайлант оны байдлаар 4 удаа хуралдаж хурлаас гарсан шийдвэрийг тухай бүрт танилцуулан ажилласан. Тооллогын тайланг нийслэлийн аудитын газар хүргүүлсэн. Тооллогоор гарсан зөрчил байхгүй.	100%

12	2.6	2024 оны улирал, хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан гаргах. Санхүүгийн болон цалингийн программыг шинэчлүүлэн сар бүрийн төсвийн төлөвлөгөөний хуваарийг программд шивж оруулах		Тайлан гаргасан тоо, Гүйцэтгэлийн хувь	6	10	Тайлант оны санхүүгийн болон цалингийн Acolous8 Payroll программыг шинэчлүүлэн сар бүрийн төсвийн төлөвлөгөөний хуваарийг программд 11 удаа шивж оруулсан, 2024 оны 03 дугаар улирлын санхүүгийн тайланг гарган баталгаажуулж Нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.	100%
13	2.7	2024 оны байгууллагын Бизнес төлөвлөгөө гаргаж батлуулан хэрэгжилтийг зохион байгуулах		Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80%	90%	2024 оны байгууллагын бизнес төлөвлөгөөг Стратегийн үндсэн зорилтууд хүрэх үр дүн, Байгууллагын 2024 оны зорилт, төлөвлөлт, Маркетингийн төлөвлөгөө, Хяналтын механизм, Санхүүгийн төлөвлөгөө гэсэн бүлгүүдээр төлөвлөсөн. 2024 оны орлогын төлөвлөгөөг 145,3 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 279,0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 134,3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн.	100%
14	2.8	Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг зохион байгуулж, архив, албан хэрэг хөтлөлтийг журмыг мөрдлөг болгон ажиллах		Гарсан зөрчлийн тоо	13	5	Байгууллагын нийт 33 ажилтан, албан хаагч нар хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг ханган өдөр тутамдаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд шинээр томилогдсон 26 албан хаагчид дотоод журмыг танилцуулан ажиллаж байна. Хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн 4 албан хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр	94%

							7 хоногийн аяныг дотооддоо зохион байгуулан тус байгууллагын 11 албан хаагч тус бүр өөрсдийн сонгож авсан сэдвээр 32 ажилтан, албан хаагчдад 7 өдрийн сургалт орсон. Байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хөтлөж холбогдох хууль тогтоомж дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:								
15	3.1	“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах		Хэрэгжилтийн хувь	90%	100%	Үндэсний их баяр наадмын бэлтгэл ажлын төлөвлөгөөнд 6 бүлгийн 43 ажил, баяр наадмын өдрүүдэд хийгдэх ажилд 4 албанд нийт 28 ажлыг хариуцуулан гүйцэтгүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг 100% ханган ажиллалаа. ҮИБН хорооноос 87,067,000 төгрөгийн санхүүжилт авч Хүй долоон худаг дах хурдан морь барианы газрын засвар, тохижилтын ажил, эко автобусаар наадамчдыг тээвэрлэх, нийтийн бие засах газруудын засвар үйлчилгээ, цэвэр усаар хангах, бохирыг татан зайлуулах ажлыг чанартай хийж гүйцэтгэн тайлагнаж ажиллав.	100%
16	3.2	“Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний дагуу төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийг эхлүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлах		Уламжилсан төслийн тоо	0	2	“Монгол наадам үндэсний спорт цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний төслийг эхлүүлж концессийн жагсаалтад оруулахаар 2024.01.18 -ны өдөр 11 тоот албан	100%

							бичгийг 9 хавсралт хуудсын хамт НЗДТГ-т хүргүүлсэн. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт 2025 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын жагсаалтад оруулахаар 2024.04.30-ны өдрийн 55 тоот албан бичиг, ажлын зураг төсөв 17 хуудас, төслийн жагсаалтын хамт хүргүүлэв.	
17	3.3	“Монгол хүү” “Эрүүл иргэн-Эко хөгжил” спорт өдөрлөг, “Хөхүүрийн айрагны баяр” арга хэмжээг зохион байгуулна.	74,9	Арга хэмжээн ий тоо	2	3	“Монгол хүү” үндэсний хүүхдийн баярын арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Хүй 7 худагт амжилттай зохион байгуулав. Баярын үеэр “Хуйран шуугигч” үндэсний хүүхдийн барилдаан, Хүүхдийн үндэсний сурын харваа, Хүүхдийн дугуйн уралдаан, Хүүхдийн гүйлтийн тэмцээн, 3х3 Сагсан бөмбөгийн тэмцээн (нас, насны ангилалаар) тухайн мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж, нийт тэмцээнүүдэд 472 хүүхэд оролцсон. Баярын арга хэмжээнд нийт 14,200 гаруй хүн оролцсон бөгөөд Тайзны арга хэмжээ, нийтийн хоол, худалдаа үйлчилгээ, хүүхдийн хөдөлгөөнт тоглоом зэрэг үйлчилгээнүүдийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 20,3 сая төгрөг зарцуулсан. 2024 оны 09 дүгээр сарын 28-ны өдрүүдэд Хүй долоон худагт байрлах гэр бааз цогцолборт “Айрагны баяр 2024” арга хэмжээг зохион байгуулсан. Дээрх арга хэмжээнд Нийслэлийн соёл урлагийн газар,	100%

							Улаанбаатар театр, Монголын сурын холбоо, шагайн холбоо, Дашчойлин хийд зэрэг байгууллагууд оролцож, хамтын ажлын харилцаагаа сайжруулж, тайзны арга хэмжээ, айрагны амталгаат худалдаа зэрэг уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулсан. Арга хэмжээнд нийт 1,200 гаруй хүн оролцож 24,7 сая төгрөг зарцуулсан. “Эрүүл иргэн-Эко хөгжил” спорт өдөрлөг арга хэмжээг 12 сард хийхээр төлөвлөсөн.	
18	3.4	Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон нийтэд зориулсан соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулах.		Хамрагдсан иргэдийн тоо	8500	23000	“Морь хурдан уу, дугуй хурдан уу” дугуйн уралдааныг Монголын дугуйн холбоотой хамтран Хүй 7 худагт зохион байгуулсан. Уг уралдаанд 298 дугуйчин оролцсон. Нийслэлийн аялал жуулчлалын газар, “Тэнгэр тайлал” холбоо хамтран зохион байгуулдаг “Тэнгэр бөөгийн олон улсын фестиваль”, “Тэсо” ХХК-ний ажилчдын дунд зохион байгуулагддаг оддын бэсрэг наадам, “Эко констракшн” ажилчдын дунд зохион байгуулагддаг наадмуудыг Хүй 7 худагт зохион байгуулахад нь талбайн тохижилт, экобус, нийтийн бие засах газрын үйлчилгээ зэргийг хариуцан хамтран ажилласан. Нийт 60,000 иргэн оролцсон.	100%
19	3.5	“Монгол Наадам” гэр баазын менежментийг сайжруулах ажлыг зохион байгуулах		Хийгдсэн ажлын тоо	1	2	“Монгол наадам” гэр баазын менежментийг сайжруулах чиглэлээр “Гэр баазын ажилтнуудын бүтэц, үйл ажиллагааны процессийн зураглал”-	100%

							ыг шинээр гаргаж батлуулан мөрдөж ажиллаж байна. Гэр баазын постеруудыг шинэчлэн цахим орчинд түгээж ажилласан. Эдгээр ажлуудын үр дүнд гэр баазын орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн.	
20	3.6	Байгууллагын цахилгаан хангамжийн хэвийн, найдвартай байдлыг хангах талаар арга хэмжээ авч ажиллах		Хийгдсэн ажлын тоо	0	1	Тайлант хугацаанд “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХК-иас Хүй долоон худагт байрлах цахилгааны агаарын шугам шинээр тавих ажил хийгдэж тус байгууллагын цахилгаан хангамж “УБЦТС” ХК-ийн бүрэн хангамжид шилжээд байна. Зуны улиралд байгалын давагдашгүй хүчин зүйлийн улмаас аянга бууж, үерт автасны улмаас цахилгаан хангамж 2 удаа саатал гарсныг мэргэжлийн байгууллагад цаг алдалгүй мэдэгдэж засварлуулж нэмэлт арчилгааны үйлчилгээг хийлгэсэн. Хүй 7 худаг оффисын уурын зуухны 380 вольтын цахилгааны тэжээлийн утас хэд хэдэн газар гэмтэл гарсныг тусдаа ил утас татан шинэ эх үүсгэвэртэй болгож засварласан.	100%
21	3.7	Байгууллагын эзэмшлийн экобусны зам, явган хүний зам, морь барианы хэсэг орчмын арчлалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах		Хийгдсэн ажлын тоо	1	2	Байгууллагын эзэмшлийн 2,7 км экобусны зам, явган хүний зам, морь барианы хэсэг орчмын арчлалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд зарцуулагдах төсөв хөрөнгийг захирагчийн ажлын албанд санал хүргүүлсэний үндсэнд Улсын баяр наадмын өмнө холбогдох	100%

							мэргэжлийн байгууллагуудаар шинэчлэн засварлуулсан. Улсын баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд морь барианы индэрийн дээвэр, шууд дамжуулалтын 2 цамхагийн дээвэр шинэчилж, цагдаагийн ерөнхий газраас 26 ш камерыг байршуулсан. Морь барианы индэр болон морь шүдэлгээний хашаанууд, шонгууд, эко автобусны зогсоолын хашлагуудаас гадна тэмдэг тэмдэглэгээний төмөр эдлэлүүдийг будаж сэргээсэн.	
22	3.8	“Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ын Улсын тусгай хэрэгцээний 11.089 га газрыг арчлах, хамгаалах, ашиглах журам боловсруулан батлуулж, мөрдөж ажиллах.		Батлуулсан журмын тоо	0	1	Журмын төслийг боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллага болон дээд газраас санал авахаар хүргүүлсэн.	70%
23	3.9	Үндэсний Их Баяр наадмын үеэр Хүй долоо худагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, худалдаачид, уяачдыг дэмжиж орлого олох нөхцөлийг бүрдүүлэх		Аж ахуйн нэгж, иргэдийн борлуулалтын орлогын хэмжээ	280,0	350,0	Үндэсний Их Баяр наадмын үеэр Хүй долоо худагт үйл ажиллагаа явуулдаг ААН, Уяачдын байрлах хэсгийг сансрын зураг дээрээс үндэслэн цементэлсэн талбайн хүрээнд зурж байршлыг тогтоосон ба ААНБ-ыг газрын хэмжээнээс шалтгаалан сонголттой олгох боломжтой байхаар төлөвлөн 2000, 3000, 5000, 12000 га талбайг төлөвлөн схем зургийг боловсруулсан. Наадмын 4 өдөрт нийт 340 иргэн, аж ахуйн нэгж байгууллага худалдаа, үйлчилгээ эрхэлж 3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн.	100%

24	3.10	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн Цасны баярын арга хэмжээг зохион байгуулж, орлого бүрдүүлнэ.		Бүрдүүлсэн орлогын хэмжээ	0	2000,0	Нийслэлийн 2 сургууль, Иргэний нисэхийн 1 албаны цасны баярыг “Монгол наадам” гэр баазад зохион байгуулж 2100,0 төгрөгийн орлого бүрдүүлсэн.	100%
ДӨРӨВ.ХОТЫН ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
25	4.1	Хотын хөгжлийн Хүртээмжтэй байдал (0.488) индексийн Соёлын хүртээмж (56) индексийг сайжруулах ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийг хангаж ажиллана.		Арга хэмжээн ий тоо	0	3	Хотын хөгжлийн индесийг сайжруулах зорилтын хүрээнд Хүй 7 худагт соёлын арга хэмжээнүүдийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар 4 ажил төлөвлөн ажиллалаа. Үүнд: “Тэнгэр” олон улсын фестиваль, “Монгол хүү 2024” үндэсний хүүхдийн баяр, “Үндэсний их баяр наадам”, “Даншиг наадам Хүрээ цам”, “Айрагны баяр” зэрэг томоохон арга хэмжээг хамтран амжилттай зохион байгуулсан.	100%
ТАВ.”ТОХИЖИЛТ-БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ЖИЛ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
26	5.1.	Ажилтан, албан хаагчдын санаачлагын дагуу “Хүүхэд нарлах хэсэг” шинээр байгуулж, ашиглалтад оруулна.		Тохижилтын ажлын тоо	0	1	Хүй 7 худагт Хүүхэд нарлах хэсгийг шинээр байгуулахаар 5х5 хэмжээтэй сүүдрэвч, хоёр хүний савлуур 1 ш , 1 хүний савлуур 2 ш -ийг шинээр хийсэн. Мөн хүүхдийн элсэн талбай, мах шарах хэсгийг байгуулсан. Нийт өртөг 6 сая.	100%
27	5.2.	Хүй долоон худгийн Хурдан морины уралдааны талбайд олон нийтэд зориулсан Тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг төрийн болон		Тохижилтын	0	1	Монголын газар зохион байгуулагчдийн холбоотой хамтран хүй 7 худагт тохижилтын ажил хийхээр урьдчилсан судалгааны ажил зураг төслүүд хийгдэж байна.	60%

	төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	ажлын тоо				“Тэмүүлэл ти ти эл” ХХК-тай хамтран Хүй долоон худагт байрлах морь барианы газрын индэрийн дээврийг сэргээн засварлаж, шинэчлэн сайжруулж ажиллалаа. Нийт 10 сая төгрөг зарцуулсан.	
Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дундаж хувь 97%							

ХЯНАСАН:
ДАРГА

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  Р.СОЛОНГО

Ц.АЛТАНГЭРЭЛ

2024 оны 12 сарын 05